



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/116-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкэр Тилли Далайван аудит" ХХК  
Утас: 99396969 Цахим хаяг: [urtaa6969@gmail.com](mailto:urtaa6969@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	4-5
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6-12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20-22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.БАТЗАЯА ТАНАА

2025.08.25 № САА-2025/116-НА-САА-0142

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 19,427.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>387,801,951.08</b>	<b>494,126,717.80</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>246,270,263.70</b>	<b>327,972,983.16</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>246,270,263.70</b>	<b>327,972,983.16</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>246,270,263.70</b>	<b>327,972,983.16</b>
31211	Төрийн сангийн харилцах	246,270,263.70	327,972,983.16
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>6,384,808.00</b>	<b>9,071,767.46</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,537,658.00	6,224,617.46
333	Татаас, санхүүжилтийн авлага	2,847,150.00	2,847,150.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>135,146,879.38</b>	<b>157,081,967.18</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>135,146,879.38</b>	<b>157,081,967.18</b>
35420	Аж ахуйн материал	134,633,179.38	156,524,217.18
35470	Бусад хангамжийн материал	513,700.00	557,750.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,981,708,496.18</b>	<b>2,047,091,671.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,981,708,496.18</b>	<b>2,047,091,671.12</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,901,922,662.57</b>	<b>1,967,314,170.83</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,608,986,177.53	1,608,986,177.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(204,165,805.08)	(226,528,517.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,443,770.94)	(11,137,223.34)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	453,340,946.90	539,780,291.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,803,068.25)	(190,427,834.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	247,830,963.68	288,546,963.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(137,559,433.17)	(147,363,581.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,159,911.00	55,159,911.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,099,007.04)	(9,184,270.72)
39217	Ном	43,113,247.94	44,919,753.64
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>79,785,833.61</b>	<b>79,777,500.29</b>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(454,166.39)	(462,499.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	79,690,000.00	79,690,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,369,510,447.26</b>	<b>2,541,218,388.92</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,239,080.29</b>	<b>2,893,649.72</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,239,080.29</b>	<b>2,893,649.72</b>
413	Өглөг	3,239,080.29	2,893,649.72
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	1,958,880.29	1,154,049.72
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,280,200.00	1,152,200.00
4136	Бусад өглөг	0.00	587,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	587,400.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,366,271,366.97</b>	<b>2,538,324,739.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,366,271,366.97</b>	<b>2,538,324,739.20</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,035,463,087.36	1,035,463,087.36

511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>156,080,934.92</b>	<b>328,134,307.15</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	156,080,934.92	116,172,700.85
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	211,961,606.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,174,727,344.69	1,174,727,344.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,369,510,447.26</b>	<b>2,541,218,388.92</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,442,015,432.68</b>	<b>3,375,225,348.35</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>122,754,656.44</b>	<b>118,860,737.78</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>122,754,656.44</b>	<b>118,860,737.78</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,641,000.00</b>	<b>10,289,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,641,000.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	10,219,100.00
120009	Бусад орлого	6,391,900.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	73,400,167.70	88,270,099.98
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	39,321,588.74	20,301,537.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,319,260,776.24</b>	<b>3,256,364,610.57</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,082,728,900.00</b>	<b>3,025,419,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,082,728,900.00	3,025,419,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,248,628.00</b>	<b>10,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,248,628.00	10,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>232,283,248.24</b>	<b>220,945,410.57</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,283,248.24	220,945,410.57
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,314,312,572.12</b>	<b>3,182,446,621.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,314,312,572.12</b>	<b>3,182,446,621.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,202,645,072.12</b>	<b>3,057,915,971.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,461,430,629.35</b>	<b>2,238,349,890.34</b>
210101	Үндсэн цалин	1,039,096,246.35	1,404,303,110.05
210102	Нэмэгдэл	360,946,598.00	710,862,795.29
210104	Урамшуулал	61,387,785.00	123,183,985.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>183,163,334.77</b>	<b>273,335,049.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	124,717,822.28	189,305,277.04
210202	Тэтгэмжийн даатгал	14,672,684.73	22,639,737.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,065,287.95	11,552,134.86
210204	Ажилгүйдлийн даатгал	2,781,214.79	9,951,021.14
210205	Эрүүл мэндийн даатгал	27,926,325.02	39,886,879.01

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>203,890,863.24</b>	<b>213,052,810.57</b>
210301	Гэрэл, цахилгаан	29,732,507.24	32,973,658.37
210302	Түлш, халаалт	161,102,356.00	166,079,152.20
210303	Цэвэр, бохир ус	13,056,000.00	14,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>354,360.00</b>
210402	Тээвэр, шатахуун	0.00	354,360.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>91,675,200.00</b>	<b>102,466,850.00</b>
210502	Хоол, хүнс	91,675,200.00	102,466,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,327,385.00</b>	<b>10,987,720.00</b>
210604	Урсгал засвар	22,327,385.00	10,987,720.00
2107	Томилолт, зочны зардал	15,580.00	0.00
210702	Дотоод албан томилолт	15,580.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,054,510.00</b>	<b>40,508,520.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,041,900.00	10,219,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,012,610.00	30,289,420.20
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>224,103,149.76</b>	<b>178,860,770.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,862,200.00	80,762,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,965,248.00	23,537,870.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	151,275,701.76	74,560,570.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,667,500.00</b>	<b>124,530,650.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>111,667,500.00</b>	<b>124,530,650.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	111,667,500.00	111,902,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	12,628,400.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>127,702,860.56</b>	<b>192,778,726.47</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	20,725,354.24
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>127,702,860.56</b>	<b>172,053,372.23</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,329,293,676.24</b>	<b>3,266,653,710.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,032,900.00</b>	<b>10,289,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,032,900.00</b>	<b>10,289,100.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,641,000.00</b>	<b>10,289,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,641,000.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	10,219,100.00
120009	Бусад орлого	6,391,900.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,319,260,776.24</b>	<b>3,256,364,610.57</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,082,728,900.00</b>	<b>3,025,419,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,082,728,900.00	3,025,419,200.00

1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,248,628.00</b>	<b>10,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,248,628.00	10,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>232,283,248.24</b>	<b>220,945,410.57</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,283,248.24	220,945,410.57
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,176,009,316.07</b>	<b>3,112,551,991.11</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,176,009,316.07</b>	<b>3,112,551,991.11</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,065,627,516.07</b>	<b>2,986,532,881.11</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,459,488,865.28</b>	<b>2,238,308,351.12</b>
210101	Үндсэн цалин	1,088,131,428.96	1,382,816,031.86
210102	Нэмэгдэл	311,285,064.32	746,059,271.50
210104	Урамшуулал	60,072,372.00	109,433,047.76
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>183,222,544.55</b>	<b>281,131,219.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	126,080,034.27	193,477,520.36
210202	Тэтгэмжийн даатгал	13,395,329.26	22,262,060.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,892,623.26	11,255,630.89
210204	Ажилгүйдлийн даатгал	3,203,811.20	10,827,161.69
210205	Эрүүл мэндийн даатгал	28,650,746.56	43,308,845.30
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>203,890,863.24</b>	<b>213,052,810.57</b>
210301	Гэрэл, цахилгаан	29,732,507.24	33,494,177.26
210302	Түлш, халаалт	161,102,356.00	165,558,633.31
210303	Цэвэр, бохир ус	13,056,000.00	14,000,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>91,675,200.00</b>	<b>99,887,600.00</b>
210502	Хоол, хүнс	91,675,200.00	99,887,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,392,385.00</b>	<b>7,892,600.00</b>
210604	Урсгал засвар	28,392,385.00	7,892,600.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,580.00</b>	<b>0.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,416,010.00</b>	<b>37,658,520.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,041,900.00	10,219,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,374,110.00	27,439,420.20
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>81,541,648.00</b>	<b>108,601,780.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,376,400.00	85,227,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,165,248.00	23,374,670.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,381,800.00</b>	<b>126,019,110.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,381,800.00</b>	<b>126,019,110.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	110,381,800.00	114,653,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	11,365,560.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>153,284,360.17</b>	<b>154,101,719.46</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	44,332,400.00	72,399,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,332,400.00	72,399,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,332,400.00	72,399,000.00
222001	Тоног төхөөрөмж	44,332,400.00	52,563,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	19,836,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(44,332,400.00)	(72,399,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	108,951,960.17	81,702,719.46
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		246,270,263.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		327,972,983.16

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	156,080,934.92	2,366,271,366.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(39,908,234.07)	(39,908,234.07)
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	211,961,606.30	211,961,606.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	156,080,934.92	2,366,271,366.97
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-39,908,234.07	-39,908,234.07
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	211,961,606.30	211,961,606.30
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	328,134,307.15	2,538,324,739.20

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,519,319,000.00</b>	<b>3,184,950,991.11</b>	<b>334,368,008.89</b>	90.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,519,319,000.00</b>	<b>3,112,551,991.11</b>	<b>406,767,008.89</b>	88.4
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,376,666,300.00</b>	<b>2,986,532,881.11</b>	<b>390,133,418.89</b>	88.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,477,876,100.00</b>	<b>2,238,308,351.12</b>	<b>239,567,748.88</b>	90.3
210101	Үндсэн цалин	1,570,910,000.00	1,382,816,031.86	188,093,968.14	88.0
210102	Нэмэгдэл	814,860,100.00	746,059,271.50	68,800,828.50	91.6
210104	Урамшуулал	92,106,000.00	109,433,047.76	(17,327,047.76)	118.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>309,412,500.00</b>	<b>281,131,219.22</b>	<b>28,281,280.78</b>	90.9
210201	Тэтгэврийн даатгал	210,400,500.00	193,477,520.36	16,922,979.64	92.0
210202	Тэтгэмжийн даатгал	24,753,000.00	22,262,060.98	2,490,939.02	89.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,376,500.00	11,255,630.89	1,120,869.11	90.9
210204	Ажилгүйдлийн даатгал	12,376,500.00	10,827,161.69	1,549,338.31	87.5
210205	Эрүүл мэндийн даатгал	49,506,000.00	43,308,845.30	6,197,154.70	87.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>221,147,000.00</b>	<b>213,052,810.57</b>	<b>8,094,189.43</b>	96.3
210301	Гэрэл, цахилгаан	36,757,900.00	33,494,177.26	3,263,722.74	91.1
210302	Түлш, халаалт	167,381,100.00	165,558,633.31	1,822,466.69	98.9
210303	Цэвэр, бохир ус	17,008,000.00	14,000,000.00	3,008,000.00	82.3
2105	<b>Нормативт зардал</b>	<b>118,006,900.00</b>	<b>99,887,600.00</b>	<b>18,119,300.00</b>	84.6
210502	Хоол, хүнс	118,006,900.00	99,887,600.00	18,119,300.00	84.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,892,600.00</b>	<b>7,892,600.00</b>	<b>0.00</b>	100.0
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>68,487,100.00</b>	<b>37,658,520.20</b>	<b>30,828,579.80</b>	55.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,332,700.00	10,219,100.00	11,113,600.00	47.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,154,400.00	27,439,420.20	19,714,979.80	58.2
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>173,844,100.00</b>	<b>108,601,780.00</b>	<b>65,242,320.00</b>	62.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,440,300.00	85,227,110.00	65,213,190.00	56.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,403,800.00	23,374,670.00	29,130.00	99.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>142,652,700.00</b>	<b>126,019,110.00</b>	<b>16,633,590.00</b>	88.3
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>142,652,700.00</b>	<b>126,019,110.00</b>	<b>16,633,590.00</b>	88.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	130,024,300.00	114,653,550.00	15,370,750.00	88.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,628,400.00	11,365,560.00	1,262,840.00	90.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>72,399,000.00</b>	<b>(72,399,000.00)</b>	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	72,399,000.00	(72,399,000.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	52,563,000.00	(52,563,000.00)	
223001	Бусад хөрөнгө	0.00	19,836,000.00	(19,836,000.00)	
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ</b>	<b>0.00</b>	<b>3,266,653,710.57</b>	<b>(3,266,653,710.57)</b>	

	ҮҮСВЭР				
<b>131</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>3,035,419,200.00</b>	<b>(3,035,419,200.00)</b>	
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	3,025,419,200.00	(3,025,419,200.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,000,000.00	(10,000,000.00)	
132	Орон нутгийн төсөв	0.00	220,945,410.57	(220,945,410.57)	
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>10,289,100.00</b>	<b>(10,289,100.00)</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	70,000.00	(70,000.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	10,219,100.00	(10,219,100.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		246,270,263.70	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		327,972,983.16	0.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь "Чадварлаг баг, чанартай сургалт, бүтээлч суралцагч" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, "Ногоон гэрэл" хөтөлбөрийг үр дүнтэй хүртээмжтэй хэрэгжүүлэх;
- Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээлийн болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах;
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх;
- Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Мэргэжил, арга зүйн байгууллага болон мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах;
- Ажлын байран дээрх эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бэхжүүлэх;
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өрчлөлтүүд**

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 171,707.8 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	246,270.30	327,973.00	81,702.70
Авлага	6,384.80	9,071.70	2,686.90
Бараа материал	135,146.90	157,082.00	21,935.10
Үндсэн хөрөнгө	1,981,708.50	2,047,091.60	65,383.10
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,369,510.50</b>	<b>2,541,218.30</b>	<b>171,707.80</b>
Өр төлбөр	3,239.10	2,893.60	(345.50)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,366,271.40	2,538,324.70	172,053.30
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,369,510.50</b>	<b>2,541,218.30</b>	<b>171,707.80</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 327,973.0 мянган төгрөг болж 81,702.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны эцсийн үлдэгдэл 9,071.7 мянган төгрөг болж өмнөөс 2,686.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр НДШ-ийн 2,699.2 мянган төгрөгийн авлага нэмж үүсгэснээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 157,082.0 мянган төгрөг болж 21,935.1 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын ерөнхий газраас 3,597.5 мянган төгрөгийн ном, сумын ОНХС-аас 16,704.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 300,421.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 298,787.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,632,195.6 мянган төгрөг болж 128,961.9 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын ерөнхий газраас 35,682.9 мянган төгрөгийн ном, компьютер, сумын ОНХС-аас 20,880.0 мянган төгрөгийн ширээ, ор үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 72,399.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 74,560.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 2,893.6 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх оны барагдуулаагүй хоолны материалын 1,152.2 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 1,152.2 мянган төгрөг, тайлант онд шинээр 587.4 мянган төгрөгийн бараа материалын өр төлбөр үүсгэснээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,397,330.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 219,039.6 мянган төгрөг нийт 2,616,370.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 9,896.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 48,144.1 мянган төгрөгөөр, мэдээллийн технологийн зардлыг 4,276.2 мянган төгрөгөөр нийт 62,316.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,678,686.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 9 удаа өөрчлөлт орж 12 дугаар сард цалин, НДШ-ийн зардлыг 761,581.3 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 13,298.4 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 7,517.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,219.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 48,016.1 мянган төгрөгөөр нийт 840,632.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 3,044,009.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 229,039.6 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 246,270.3 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт **3,519,319.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 3,519,319.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,184,951.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,184,951.0 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа үдийн цайны зардлыг 15,370.7 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 36,508.1 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 282,489.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							<i>/мянган төгрөгөөр/</i>	
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт	
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	5,828.5	5,828.5	-	100.0	
		2	80233 хүүхэд хамгаалал	6,163.4	5,476.9	686.5	88.9	
		3	80312- Сургалт семинар	4,220.5	2,473.5	1,747.0	58.6	
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	5,828.5	4,905.5	923.0	84.2	
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	130,024.3	114,653.6	15,370.7	88.2	
		6	81806- Дотуур байрны үйлчилгээ	339,666.3	303,158.2	36,508.1	89.3	
		7	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	52,719.9	49,911.0	2,808.9	94.7	

8	81823- Боловсролын багшийн сургалт	17,485.5	10,086.2	7,399.3	57.7
9	81827 - Бичиг үсгийн боловсрол	8,160.6	89.8	8,070.8	1.1
10	81834- Боловсролын стандарт сургалт	2,569,319.5	2,336,436.1	232,883.4	90.9
11	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	116,934.5	99,621.3	17,313.2	85.2
12	81848-Сурах бичгийн түрээс	10,219.1	10,219.1	-	100.0
13	81844-Гүнзгийрүүлсэн төрөлжсөн	253.7	253.7	-	100.0
14	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр	11,113.6	8,550.8	2,562.8	76.9
15	83603-Дээд шатнаас хуваарилсан	12,341.5	12,341.4	0.1	100.0
16	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	229,039.6	220,945.4	8,094.2	96.5
<b>Нийт</b>		<b>3,519,319.0</b>	<b>3,184,951.0</b>	<b>334,368.0</b>	<b>90.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн хоол	122,507.1	101,946.7	НТШ
2	Дотуур байрны хоол	104,708.5	88,638.2	НТШ
<b>Нийт дүн</b>		<b>227,215.6</b>	<b>190,584.9</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт 3 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Ноён Уул” ХХК-тай гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,314,328.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,143.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 6,775.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, авлага, бараа материал, зардалтай холбоотой 3,999.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж авлага үүсгэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул **37.1** хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	6,775.3			
Зөвлөмж	3	3,999.7	3	3,999.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>10,775.3</b>	<b>3</b>	<b>3,999.7</b>	<b>37.1</b>

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өглөг үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ....бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэнд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **26,152.1** мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Санхүүгийн тайланд 10,219.0 мянган төгрөгийг түрээсийн номын орлого, 3,448.0 мянган төгрөгийн авлага тусгаагүй, 402,8 мянган төгрөгийн өглөг илүү тусгасан,
- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 8,224.3 мянган төгрөгөөр, НДШ-н зардлыг 3,858.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **14,003.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **10,716.6** мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, **3,286.6** мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар захирамжаар захирал А.Батзаяад ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу **1,404.0** мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь *“Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт *“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох*

шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй багш ажилтнуудад **3,179.9** мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн **төрийн албан** хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас ... бодож олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тооцооллын алдаанаас шалтгаалж 5 багшийн ажилласан хоногийг зөрүүтэй тооцож **1,589.5** мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон 3 багшид ажилласан хоногийг зөрүүтэй тооцож **443.5** мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5. Илүү цаг ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажил, цагийн тооцоогүйгээр нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэн, нярав А.Тунгалагтуяа нарт сар бүр 16 цагийн илүү цагийн нэмэгдэл тооцож, нийт 4,099.7 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, ...ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн

цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ". 3.2: "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, .....ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Албан шаардлага

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн 2,699.2 мянган төгрөгийн авлага, 587.4 мянган төгрөгийн бараа материалын өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх "...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэнд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлага дутуу тусгасан	1	3,448.0	1	3,448.0			1	3,448.0				
Санхүүгийн тайланд өглөг илүү тусгасан	1	402.8			1	402.8	1	402.8				
Орлого тусгаагүй	1	10,219.0	1	10,219.0			1	10,219.0				
Цалин, НДШ-ийн зардал илүү тусгасан	2	12,082.3			2	12,082.3	2	12,082.3				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>26,152.1</b>	<b>2</b>	<b>13,667.0</b>	<b>3</b>	<b>12,485.1</b>	<b>5</b>	<b>26,152.1</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	10,716.6	1	10,716.6								
Авлага, өглөг үүсгэсэн	1	3,286.6							1	3,286.6		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>14,003.2</b>	<b>1</b>	<b>10,716.6</b>					<b>1</b>	<b>3,286.6</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Нийт дүн</b>								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.